



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 283

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.3, 6.4.4, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өмнөговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй нь Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 16/07/051/02 дүгнэлтээр тогтоогдсон, 65,240,238.00 (жаран таван сая хоёр зуун дөчин мянга хоёр зуун гучин найм) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан барилгыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга бөгөөд Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алимаа, Өмнөговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Б.Должинсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Акталсан барилгын доорх Өмнөговь аймаг, Даланзадгад сум, Далан-3-д байрлах 2764 м.кв газрыг зориулалтаар нь ашиглах, төрийн байгууллагын мэдэлд хэвээр үлдээх, төрийн өмчийн Ахмадын сувиллын барилга барих, нөхөн сэргээх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ
132001544
15-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 05 дугаар сарын 30 өдрийн
283 дугаар тогтоолын хавсралт



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ БАРИЛГА

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон он	Тоо ширхэг	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ахмадын сувиллын барилга /Өмнөговь аймаг, Даланзадгад сум, Далан-3/	1963	1	65,240,238.00	65,240,238.00	0
Нийт дүн				65,240,238.00	65,240,238.00	-
				(жаран таван сая хоёр зуун дөчин мянга хоёр зуун гучин найм)	(жаран таван сая хоёр зуун дөчин мянга хоёр зуун гучин найм)	